



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЗҮҮНБҮРЭН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН НАМД

2024.08.06 № ГНАГ-2024/13-МТА-НА-07
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Зүүнбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Зүүнбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Монгол Ардын намын Зүүнбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Зүүнбүрэн сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (...᠘. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Зүүнбүрэн сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА



**ЗҮҮНБҮРЭН СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024-2028

**ЗҮҮНБҮРЭН СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО
2024 ОН**

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗҮҮНБҮРЭН СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС ДЭВШҮҮЛЖ БУЙ МӨРИЙН
ХӨТӨЛБӨР**

2024.06.19

ЗҮҮНБҮРЭН СУМАА ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬЕ



Зүүнбүрэн сумын ард иргэд, зон олны итгэл, сонголтыг хүлээн ялалт байгуулахыг зорьж нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийг Монгол улсын хөгжлийн алсын хараа, ирээдүйн чиг хандлагыг иш үндэс болгон Монгол Ардын Намаас УИХ-ын 2024 оны сонгуульд дэвшүүлсэн хөгжлийн зорилтуудыг орон нутагтаа зохион байгуулж гардан хэрэгжүүлснээр нутгийнхаа хөгжлийг шинэ шатанд гаргах шаардлагын үүднээс сум орон нутгийнхаа ард иргэд, ААН, ТББ-аас ирүүлсэн саналуудыг нэгтгэн дүгнэж, 2024-2028 онд Зүүнбүрэн нутгийнхаа хөгжил, дэвшил хүн ардынхаа сайн сайхны төлөө хийж хэрэгжүүлэх гол ажил, арга хэмжээг хураангуйлан тусгасан мөрийн хөтөлбөрөө Зүүнбүрэн сумын МАН-ын Хороо сонгогчид та бүхэндээ өргөн барьж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОЛОВСРОЛ СОЁЛ

- 1.1 Өсвөр үеийнхэнд эх оронч үзэл, уламжлалт зан үйл сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор орон нутгийн түүх соёл, уламжлалт зан үйл, үнэт зүйлсийн тухай мэдлэгийг сургалтын агуулгад багтаан олгоно.
- 1.2 “Элэг бүтэн Монгол”, “Хавдаргүй Монгол”, хүүхдийн “Эрүүл шүд”, “Эрүүл хүүхэд”, хөтөлбөрүүдийг үргэлжлүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.3 Малчин өрхийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох явуулын гэр цэцэрлэгийг тогтмол ажиллуулж, эцэг эхчүүдийн боловсролыг дээшлүүлэх замаар тэдний оролцоонд түшиглэн бага насны хүүхдийн хөгжлийг дэмжинэ.
- 1.4 Сумын соёлын төв, номын санг байнгын ажиллагаатай байлгаж, үйлчилгээний нэр төрлийг олшруулан иргэдийн соёлын хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлнэ.
- 1.5 Бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлж, сумын түүх, хэл соёл, үндэсний өв уламжлал, ёс заншил, эх оронч сэтгэлгээг тусгаж хэрэгжүүлнэ.
- 1.6 Боловсролын тухай хуульд англи хэлийг үндсэн гадаад хэлээр тодорхойлсны дагуу бүх шатны сургалтын байгууллагад англи хэлийг эзэмших нөхцөл, орчныг бүрдүүлж, англи хэлний багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулна.
- 1.7 Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.
- 1.8 Тусгай хэрэгцээт хүүхдийг сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.9 “Монгол хүн-Монгол ахуй-Монгол соёл-Монгол урлаг” бодлогыг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлнэ.
- 1.10 “Соёлч иргэн”, “Соёлч гудамж”, “Соёлч хамт олон” хөтөлбөрийг хэрэгжүүлэн аж ахуйн нэгж, байгууллагууд сар бүр соёлын ажлыг зохион байгуулдаг тогтмол өдөртэй болж, иргэдийн идэвх санаачилга дээр тулгуурлан сум, багт соёлыг дэлгэрүүлнэ.



ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЭРҮҮЛ МЭНД, БИЕЙН ТАМИР, СПОРТ
Эрүүл, чийрэг иргэн – Идэвхтэй амьдрал

- 2.1 Сумын хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, эндэгдлийн шалтгааныг судлан тогтоож урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэхэд эмнэлгийн тусламж үйлчилгээг чиглүүлнэ.
- 2.2 Иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд заавал хамрагддаг болгож хэвшүүлнэ.
- 2.3 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.
- 2.4 Мангиртын 3-р баг, Бэлчир 2-р багийн нутагт амьдарч байгаа малчид үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж, чанар, төв суурин газарт амьдрагчтай ижил төвшинд хүргэх бодлого барьж ажиллана.
- 2.5 Сумын эрүүл мэндийн салбарт дутагдалтай, нарийн мэргэжлийн эмчээр амжилттай суралцаж байгаа, сургуулиа төгсөөд орон нутагтаа ирж ажиллах Зүүнбүрэн сумын харъяат оюутанд орон нутгийн төсвөөс олгох дэмжлэгийг бий болгоно.
- 2.6 Хүн ам, хүүхэд залуучуудын бие бялдрын хөгжлийг дэмжих зорилгоор уламжлалд үндэслэн спортын заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож мөрдүүлнэ.
- 2.7 Сумын хэмжээнд цар тахлын халдвар дэлгэрэхээс сэргийлэх дэг журмыг мөрдөж хэрэгжүүлнэ.
- 2.8 Иргэдийг идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамир спортоор хичээллэх сонирхлыг төрүүлэх, орчныг бүрдүүлэх, сайжруулах, эрүүл чийрэг амьдралыг төлөвшүүлэхэд биеийн тамир, спортын салбарын үйлчилгээг чиглүүлнэ.
- 2.9 Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт тусгагдсан шатар, цана, тэшүүрээр хичээллүүлэх дугуйлан, секцийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 2.10 Төрийн албан хаагчдын дунд спортын олон төрөлтийн тэмцээнийг жил бүр ойролцоох сумуудтай хамтран бүсийн хэмжээнд зохион байгуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. АМЬДРАЛЫН ТААТАЙ ОРЧИН
Сэтгэл тайван иргэн – Аз жаргалтай амьдрал

- 3.1 Эрүүл мэндийн болон орчны тандалт нөлөөллийн үнэлгээ хийж агаар, хөрс, усны бохирдлыг багасгах арга хэмжээ авснаар эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлнэ.
- 3.2 Ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэх, хамгаалахад иргэдийн оролцоог дээшлүүлнэ.
- 3.3 Интернэтийн хурдыг нэмэгдүүлснээр иргэдийн интернэтийн хэрэглээ сайжирна.
- 3.4 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд эхний гурван жилд 3 хувийн зээлийн хүүтэй, ипотекийн зээлийн 6 хувийн хүүтэй хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.5 Хувиараа болон гэр бүлээрээ ажил хөдөлмөр эрхлэх, шинэ ажлын байр бий болгохыг дэмжиж өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 3.6 Олон нийтийг хамарсан халдварт өвчин, цар тахал, байгалийн гамшиг зэрэг аюулыг эрсдэлгүй даван туулахад бэлдэж, нэгдсэн стратеги бүхий бэлэн байдлын цогц эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, жил бүр тодотгож хэрэгжүүлнэ.
- 3.7 Өрхийн амьжиргааны түвшин тогтоох аргачлалыг сумын онцлогт тохируулан боловсронгуй болгож, гэр бүлийн гишүүн бүрд үзүүлэх нийгмийн халамж,


- тусламж, дэмжлэгийг олон нийтийн оролцоотойгоор бодитой тогтоож дэмжлэгийн чанар, хүртээмжийг сайжруулна.
- 3.8 Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүйн хөгжлийн хэрэгцээг дэмжихэд чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.
 - 3.9 Ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүст хувиараа хөдөлмөрлөх, аж ахуй эрхлэх боломжийг олгож, гэр бүлийн амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэн, хаврын тариалалт, ургац хураалт, хадлан бэлтгэл зэрэг сумын онцлогтой ажлын үед ажлын цагт өөрчлөлт оруулж, зайнаас ажиллахыг дэмжих бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ.
 - 3.10 Залуу гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээ нэвтрүүлэхэд дэмжлэг өгч ажиллана.
 - 3.11 Гадаад дотоодын төсөл хөтөлбөр, улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр эмзэг бүлгийн, олон ам бүлтэй айл өрх, залуу гэр бүлийг малжуулах арга хэмжээг бодлогоор дэмжинэ.
 - 3.12 Гамшигт үзэгдлүүд (*ган зуд, газар хөдлөлт, хүчтэй шороон шуурга, үер, гал түймэр г.м*)-ийн тархалт, давтамж, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл аюулын талаар судалгааг тогтмол явуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮНД ЭЭЛТЭЙ АМЬДРАХ ОРЧИН

- 4.1 Сум, суурин газарт эрүүл мэндийн болон орчны тандалт нөлөөллийн үнэлгээ хийж агаар, хөрс, усны бохирдлыг багасган эрүүл аюулгүй орчинг бүрдүүлнэ.
- 4.2 Хог хаягдлын цогц менежментийг хэрэгжүүлэн одоо байгаа хогийн цэгийг хашаажуулж ажиллана.
- 4.3 Сумын төвийн хэсгийг инженерийн дэд бүтэцтэй болгох ажлыг улс аймгийн төсвөөр дэс дараатай хийж гүйцэтгэнэ.
- 4.4 Томоохон аж ахуйн нэгж, үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд жижиг, дунд үйлдвэрийг дэмжих санал, санаачилгыг урамшуулж, дэмжих замаар кластерын хөгжлийг хангана.
- 4.5 Өрхийн аж ахуйн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ бий болгох ажлыг эхлүүлнэ.
- 4.6 Бизнес эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, технологийн дэвшлийг ашиглаж хүний оролцоо, төрийн хүнд суртлыг арилгана.
- 4.7 Ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн хүртээмжийг нэмэгдүүлж, шударга, ил тод олгох зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.
- 4.8 Иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн зорчигч тээврийн үйлчилгээг нэмэгдүүлж, аюулгүй байдлыг хангана.

ТАВДУГААР БҮЛЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ Хөдөлмөрч иргэн – Элбэг хангалуун амьдрал

- 5.1 Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 5.2 Үндэсний экспортлогч Болдтөмөр-Ерөө гол, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, Дархан-уул аймгийн компаниудтай иж бүрэн түншлэлийн гэрээ байгуулж сумын Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, малчид, ногоочдын түүхий эд, бүтээгдэхүүнийг тогтвортой бэлтгэж нийлүүлэх сүлжээ тогтолцоог бий болгоно.

- 
- 5.3 Сумдын нөхөрлөл, хоршоо, иргэд гэр бүлээрээ ба хувиараа бизнес эрхлэгчийг санхүүгийн болон зах зээлтэй холбож, улс, аймгийн бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээнд холбож өгнө.
- 5.4 Хоршоо, нөхөрлөлд гишүүнээр элсэн ажиллах хүсэлтэй ажилгүй, иргэдийн саналыг үндэслэн зуучлах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 5.5 Орон нутгийн иргэдийн бие даасан, бүтээлч байдлыг дэмжих зорилгоор "нэг суурин-нэг бүтээгдэхүүн" аяныг үргэлжлүүлэн өрнүүлнэ.
- 5.6 Сумын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч иргэдийг гарааны бизнес эхлэхэд зөвлөгөө олгодог болно.
- 5.7 Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох үйл ажиллагаанд идэвхтэй оролцох санал санаачилгыг дэмжиж, сургалт сурталчилгаа зохион байгуулна.
- 5.8 Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй Болдтөмөр-Ерөө гол, Элч Хужирт, Ред-хилл Монголия зэрэг томоохон аж ахуй нэгжид Зүүнбүрэн сумын иргэд, залуучуудыг ажиллах боловсон хүчнийг тоог нэмэгдүүлж ажиллана.
- 5.9 Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулан хөгжүүлэх бодлого баримтална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Нэг. Аялал жуулчлал

- 6.1.1 Сумын аялал, жуулчлалын агентлаг, аяллын операторын чиглэлээр нэн шаардлагатай хүний нөөц, мэргэжилтэн бэлтгэнэ.
- 6.1.2 Сумын аялал жуулчлалын маршрут, зар сурталчилгааг сайжруулж хөгжүүлнэ.
- 6.1.3 Сумын соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, нутгийн иргэдэд түшиглэсэн /НИТАЖ/ аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 6.1.4 Монголын их түүх, шашин, соёлын хадгалагдаж үлдсэн өв, тусгай хамгаалалттай газар нутгийн нөөц, даацад тулгуурласан эко аялал жуулчлал болон Сэлэнгэ, Орхон голуудын сав дагуух спорт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 6.1.5 Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжих бодлого баримтална.
- 6.1.6 Зүүнбүрэн сумын дотоодын нийт бүтээгдэхүүний зонхилох хувийг эзэлдэг газар тариалан, төмс хүнсний ногоо тариалдаг хэмжээг нэмэгдүүлнэ.

Хоёр. Аж үйлдвэр

- 6.2.1 ЖДҮ-н салбарт олгож байгаа төрийн болон олон улсын байгууллагын зээл тусламжийн санхүүжилтийг сумандаа татах, оролцогч талуудын уялдааг сайжруулна.
- 6.2.2 Сумандаа ХАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах, мод модон эдлэлийн цех, мал бордох газар зэрэг ХАА, хөнгөн үйлдвэрийн түүхий эд бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх загвар төслүүдийг орон нутгийн онцлогт тулгуурлан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 6.2.3 Барилгын хийц, хэсгүүд үйлдвэрлэх хувийн хэвшлийг дэмжиж, жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн аж ахуйн эрхлэгчдийн бүтээмжийг нэмэгдүүлж, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлж чанар, стандартын шаардлага хангасан, үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.

Гурав. Газар тариалан

- 6.3.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн дөрвөн улиралд бэлтгэн нийлүүлэх, хадгалах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ. Газар тариалангийн салбарт ашиглаж байгаа эргэлтийн талбайн хөрсийг хамгаалах, үржил шимийг нэмэгдүүлэх чиглэлээр тухайн эзэмшигчдийн хүлээх үүргийг өндөржүүлнэ.
- 6.3.2 Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, эрт ургацын ногооны тариалалтыг нэмэгдүүлнэ
- 6.3.3 Хүлэмжийн аж ахуй, агуулах /зоорь/-ын аж ахуйг дагнан эрхлэгчдэд тэргүүн ээлжид зоорь барих зураг төслийг бий болгож дэмжлэг үзүүлэн, “хураалт – хадгалалт – боловсруулалт”-ын сүлжээ байгуулна.
- 6.3.4 Малын тэжээл тариалалтыг таримлын сэлгээнд оруулж, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн сумын аюулгүйн нөөцийг нэмэгдүүлнэ.
- 6.3.5 Хөрс хамгаалалт, хөрс боловсруулалт, тариалалт, усалгаа, хураалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт, жижиглэн худалдааг хамарсан төмс, хүнсний ногооны мөшгөлтийн мэдээллийн тогтолцоог бий болгон хүнсний аюулгүй баталгаат байдлыг хангана.
- 6.3.6 Тариалангийн хөрсний үржил, шимийг нэмэгдүүлэх, хөрс бордох, үр ашигтай технологийг нэвтрүүлэх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, бордооны хангамжийг 70 хувьд хүргэж, хөрсний шим тэжээлт чанарыг нэмэгдүүлнэ.

Дөрөв. Мал аж ахуй

- 6.4.1 Мал эмнэлгийн үйлчилгээг шинэ шатанд гарган сайжруулж, гоц халдварт өвчингүй сум болох зорилт тавьж, мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 6.4.2 Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малчин өрхийн амьжиргааг дэмжин, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний мөнгөн урсгалыг тогтмолжуулж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.
- 6.4.3 Хоршоололд суурилсан хамтын хариуцлагын 3-5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээл, хагас эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 6.4.4 Бэлчээр ашиглалтыг уламжлалт аргад үндэслэн улирлын хуваарьтай малын тоо, төрлийн харьцаанд зохицуулан ашиглаж, бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛ ОРЧИН – НОГООН ХӨГЖИЛ

- 7.1 Бэлчээрийг усжуулах, ажлыг үргэлжлүүлэн, бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, газар зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж зохистой ашиглан хамгаалж, нөхөн сэргээх, малчдын дундын санг бий болгоно.
- 7.2 Сумын ногоон байгууламж, гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж камержуулах, мод зүлэг суулгах, тохижуулах бүх нийтийн хөдөлгөөнийг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоонд тулгуурлан өрнүүлнэ.
- 7.3 Байгалийн нөөц ашигласны нөхөн төлбөр буюу түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны орлогыг байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд зориулах үндсэн зорилгоор нь үр дүнтэй ашиглаж, байгаль хамгаалах үйлсэд төрийн бус байгууллагууд, ААН, олон нийтийн оролцоог бүх талаар дэмжинэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ. ШУДАРГА ЁСНЫ ЗАСАГЛАЛ

Иргэнд ойрхон төрийн үйлчилгээ

- 8.1 Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 8.2 Төрийн аливаа шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг зөрчсөн шийдвэрийг цуцалж, төрийн хүнд суртлыг арилгана.
- 8.3 Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай нийгмийг соён гэгээрүүлэхэд хамтран ажиллана.
- 8.4 Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.
- 8.5 Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж мэдээллийг ил тод, шилэн байлгана.
- 8.6 Бүх нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээний шийдвэрийг гаргахаас өмнө иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлдэг тогтолцоог бүрдүүлнэ.
- 8.7 Эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг оновчтой болгож, орон нутгийн засаглалын тогтвортой, шударга, бүтээлч байдлыг хангана
- 8.8 Төрийн албан хаагчийн цалин хөлс, шагнал, урамшуулал олгох, албан тушаал дэвшүүлэх, бууруулах, халах, чөлөөлөхөд тухайн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарах тогтолцоог төлөвшүүлнэ.
- 8.9 Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний чухал хэсэг болгон хэвшүүлж, үйлчилгээний соёлыг дээшлүүлнэ.
- 8.10 Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.
- 8.11 Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа ажил, арга хэмжээнд дотоод аудитыг чанартай гүйцэтгэж үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлнэ.
- 8.12 Татварын шинэ хуулийг хэрэгжүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ.
- 8.13 Хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжиж, хамтран ажиллана.
- 8.14 Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ /хөгжлийн бэрхшээл/-тэй иргэдэд үйлчлэх түр хамгаалах байр, мэдээлэл зөвлөгөөг авах төвийг сумандаа ажиллуулна.
- 8.15 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 8.16 Төсөв санхүүгийн сахилга хариуцлагыг чангатгаж, төсвийн хөрөнгийг нийгэм, эдийн засгийн хөгжилд оновчтой, үр ашигтай зарцуулахад иргэд, олон нийтийн хяналтыг нэмэгдүүлнэ.

Зүүнбүрэн сумын МАН-ын Хорооноос 2024 оны сумын ИТХ-ын сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа энэхүү хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн зорилтуудыг Зүүнбүрэн нутгийн ард иргэд та бид хамтран хэрэгжүүлж, ардын хувьсгалыг гардан хийж, шинэ Монгол улсын эх суурийг тавьсан өвөг дээдэс, их бүтээн байгуулалтын он жилүүдэд эх орноо аж үйлдвэржүүлж, атар газар эзэмшин, хүн ардаа хүнсээр хангах амин чухал хэрэгцээг хангаж ирсэн ахмад үеийнхээ түүхэн уламжлалыг хадгалж, хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхныг хамтран бүтээхийн төлөө Зүүнбүрэнчүүд бид сумаа “ХАМТДАА ХӨГЖҮҮЛЬ”.